



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 479

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны харьяа “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 50,402,860.20 (тавин сая дөрвөн зуун хоёр мянга найман зуун жаран төгрөг хорин мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн зохицуулагч Х.Болор-эрдэнэ, Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга н.Цэдэнгомбо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201989

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020
оны 10 дугаар сарын 06-ний
өдрийн 479. дугаар тогтоолын
хавсралт

**Сангийн яамны харьяа Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй тэг үлдэгдэлтэй хөрөнгийн үнийг шинэчлэн
тогтоож балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

д/д	Хөрөн гийн нэр	Ашиглал тад орсон он	тоо шир хэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл/төгрөг/	Шинэчлэн тогтоох үнэ	цаашид ашиг лах жил	Хүлээн авах байгуул лага
2	Тоёото Ланд крузейр- 105	2005	1	50,402,860.20	50,402,860.20	16,800,953.40	2 жил	Орхон аймаг МХГазар
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2 (хоёр)		50,402,860.20 (тавин сая дөрвөн сая зуун хоёр мянга найман зуун жаран төгрөг хорин мөнгө)	16,800,953.40 (арван зургаан сая найман зуун мянга есөн зуун тавин турван төгрөг дөчин мөнгө)		